

МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 10 дугаар  
сарын 11-ны өдөр

Дугаар 112/152

Улаанбаатар  
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Өсвөрийн сэргийлэгч сайн дурын бүлгэмийн ажиллах журам"-ыг нэгдүгээр, "Өсвөрийн сэргийлэгчийн таних тэмдгийн загвар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг бүх шатны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, боловсролын газар, хэлтэс, цагдаагийн байгууллагын дарга нарт даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Э.Энхтуяа/, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга /Д.Эрдэнэчимэг/ нарт даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



С.БЯМБАЦОГТ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ЧУЛУУНБААТАР

Хууль зүй, дотоод хэргийн сайд,  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан,  
спортын сайдын хамтарсан  
2017 оны 11-р сарын 14-дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

## ӨСВӨРИЙН СЭРГИЙЛЭГЧ САЙН ДУРЫН БҮЛГЭМИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журам нь ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэг, мэргэжлийн чиг баримжаа олгох зорилго бүхий "Өсвөрийн сэргийлэгч бүлгэм" /цаашид "Бүлгэм" гэх/ ажиллуулахад энэхүү журмыг мөрдөнө.

### Хоёр.Бүлгэмийн зохион байгуулалт, удирдлага

2.1.Өмчийн хэлбэр харгалзахгүй ерөнхий боловсролын сургуульд бүлгэм ажиллана.

2.2.Бүлгэмийн гишүүд тухайн сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдын төлөөллөөс бүрдэнэ. Тухайн суралцагчийн хүсэлт, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл болон ангийн хамт олны саналыг үндэслэн бүлгэмийн гишүүнийг сонгож, сургуулийн захирлын тушаалаар томилж, чөлөөлнө.

2.3.Бүлгэмийн гишүүн нь анги хамт олныхоо дунд нэр хүндтэй, бусдад үлгэр дууриал болохуйц сурагч байна.

2.4.Бүлгэмийн дарга нь сургуулийн нийгмийн ажилтан байна.

2.5.Бүлгэмийн үйл ажиллагааг жилээр төлөвлөж, төлөвлөгөөг сургуулийн захирал батлана.

2.6.Бүлгэмийн үйл ажиллагаа нь 09 дүгээр сарын 15-ны өдрөөс дараа оны 5 дугаар сарын 15-ны хугацаанд явагдана.

2.7.Бүлгэмийн гишүүн нь энэхүү журмаар батлагдсан таних тэмдгийг зүүж хэрэглэнэ. Таних тэмдгийг аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл олгоно. Бүлгэмийн гишүүнээс чөлөөлөгдөх тохиолдолд таних тэмдгийг буцаан өгнө.

2.8.Бүлгэмийн гишүүн нь хүсэлт гаргасан, сургуулиа төгссөн, шилжсэн, сахилгын зөрчил гаргасан, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн нь түүнийг чөлөөлөх үндэслэл болно.

2.9.Бүлгэмийн дарга нь бүлгэмийн үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр гарган сургуулийн удирдлагад танилцуулж, аймаг, нийслэлийн Гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, харьяа нутаг дэвсгэрийн боловсролын газарт тус тус хүргүүлнэ.

2.10.Бүлгэм нь хийж гүйцэтгэсэн ажил, үр дүнгийн талаар мэдээллийн самбар болон бусад арга хэрэгслээр эцэг эх, суралцагч, сургуулийн удирдлага, багш нарт мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулна.

### **Гурав. Бүлгэмийн үйл ажиллагааны чиглэл**

3.1. Бүлгэм нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1.Сургуулийн орчин болон сургуулийн ойр орчинд учирч болзошгүй эрсдэлийг судлан тодорхойлох, хичээл эхлэх, тарах болон завсарлагааны цагт сайн дурын эргүүл хийх,

3.1.2.Сургуулийн холбогдох хууль тогтоомж болон сургуулийн дотоод дэг журмыг тогтмол сурталчлан таниулах, дагаж мөрдөх, биелүүлэх талаар сурагчдад шаардлага тавьж, хэрэгжилтийг хангуулах,

3.1.3.Суралцагчийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор төрөл бүрийн уралдаан, тэмцээн, уулзалт, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг сургуулийн удирдлага, эцэг эхийн зөвлөлтэй хамтран зохион байгуулах,

3.1.4.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдсэн, илрүүлсэн тохиолдолд нийгмийн ажилтан, сургуулийн захиргаанд мэдэгдэх,

3.1.5.Сурагчдын өмнө тулгамдаж байгаа зарим асуудал, сургуулийн орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, холбогдох дүрэм, журмын биелэлтийн талаар хэлэлцэн, хэрэгжүүлэх ажлын саналыг сургуулийн удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх,

3.1.6.Сургууль дээр зохион байгуулагдаж буй нийтийн арга хэмжээний үеэр дэмжлэг үзүүлэх шаардлагатай тохиолдолд сургуулийн захиргаатай хамтран ажиллах.

### **Дөрөв.Бүлгэмийн гишүүдийн эрх, үүрэг**

4.1.Бүлгэмийн гишүүн дор дурьдсан эрхтэй байна:

4.1.1.Холбогдох хууль тогтоомж болон сургуулийн дотоод дүрэм, журмыг дагаж мөрдөх талаар сурагчдад шаардлага тавьж, хэрэгжилтийг хангуулах,

4.1.2.Суралцагчийн болон сургуулийн дотоод дүрэм, журмыг хэрэгжилтийг удаа дараа зөрчсөн суралцагчийн талаар сургуулийн нийгмийн ажилтанд мэдэгдэх,

4.2.Бүлгэмийн гишүүн дор дурьдсан үүрэгтэй байна:

4.2.1.Энэхүү журамд заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулахдаа сургуулийн нийгмийн ажилтан болон бүлгэмийн даргаас өгсөн хууль ёсны үүрэг, зааварчилгыг мөрдөх.

4.2.2.Холбогдох хууль тогтоомж болон сургуулийн дотоод дүрэм, журмыг дагаж мөрдөх талаар сурагчдад танилцуулах, мэдээлэл өгөх,

4.2.3.Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг сургуулийн нийгмийн ажилтан болон цагдаагийн байгууллагад нэн даруй мэдээлэх,

4.2.4.Бусдыг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн байдал, эрхэлсэн ажил, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхахгүй байх,

4.2.5.Үүрэг гүйцэтгэх үедээ олж мэдсэн, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон болон хохирсон хүүхдийн талаарх болон хувь хүний нууцтай холбоотой мэдээ, мэдээллийг бусдад задруулахгүй байх.

#### **Тав.Бүлгэмийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх**

5.1.Сургуулийн захирал нь бүлгэмийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй ажиллана:

5.1.1.Бүлгэмийн үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг сургуулийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгах,

5.1.2.Бүлгэмийн зохион байгуулж байгаа арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран зохион байгуулах,

5.1.3.Бүлгэмийн тайлан, санал, мэдээллийг холбогдох журмын дагуу шийдвэрлэх.

5.1.4.Бүлгэмийн гишүүдийг сургаж дадлагжуулах, чадавхжуулах, туршлага судлуулах ажлыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах.

5.2.Цагдаагийн байгууллага нь бүлгэмийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй ажиллана:

5.2.1.Бүлгэмийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, шаардлагатай гарын авлага, материалаар хангах, сургалт хамтран зохион байгуулах,

5.2.2.Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран оролцох.

5.2.3.Бүлгэмийн гишүүдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чадавхжуулах чиглэлээр сургалт зохион байгуулах.

5.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл /салбар зөвлөл/ нь бүлгэмийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй ажиллана:

5.3.1.Бүлгэмийн гишүүдэд эрх зүйн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах,

5.3.2.Бүлгэмээс зохион байгуулж байгаа хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран оролцох,

5.3.3.харьяа нутаг дэвсгэрийн бүлгэмийн ажлын төлөвлөгөө, тайлан мэдээнд хагас, бүтэн жилээр дүн шинжилгээ хийж, үнэлэлт өгөх,

5.3.4.бүлгэмүүдийн дунд туршлага солилцох уулзалт, өдөрлөг, уралдаан, тэмцээн, сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, сурталчлах.

### **Зургаа. Бүлгэмийн гишүүдийг урамшуулах**

6.1.Бүлгэмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, бусдыгаа манлайлан ажилласан гишүүнийг сургуулийн захиргаанаас сургуулийн дотоод дүрэм, журмын дагуу урамшуулах болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл /салбар зөвлөл/-ийн шагналд нэр дэвшүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

6.2.Журмын дагуу идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бүлгэм, түүний гишүүдэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажилласан багш, сурагч, эцэг, эхийг боловсролын болон цагдаагийн байгууллагын саналыг харгалзан Аймаг нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл шагнаж урамшуулж болно.

6.3. Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн даргын шийдвэрээр аймаг нийслэлийн салбар зөвлөлийн тодорхойлолтыг үндэслэн нийслэлээс -1, орон нутгаас нэг хүүхдийг шалгаруулж "Өсвөрийн сэргийлэгч" хүндэт тэмдгээр шагнана.

9.1.Онц хүнд, ноцтой гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл өгсөн сурагчид бүлгэмийн гишүүн эсэхээс үл хамааран энэ журмын 9.3-д заасан шагналыг олгож болно.

### **Арав. Бусад**

10.1. Бүлгэмийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улс, орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төсвөөс гаргана.

Хууль зүй, дотоод хэргийн сайд,  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан,  
спортын сайдын хамтарсан  
2017 оны *Няса Няса* дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

### ТАНИХ ТЭМДГИЙН ЗАГВАР

1.Өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн таних тэмдгийн суурь өнгийг амжилт, оюун ухаан, сэтгэн бодох чадвар, авъяасыг билэгдэж шар өнгөөр хийж, "Өсвөрийн сэргийлэгч бүлгэм" гэсэн үгийг итгэлцэл, үнэнч байдлыг илтгэдэг цэнхэр өнгөөр сийлж, тэмдгийн голд зургаан хошуу дүрс дээр цагдаагийн байгууллагын билэг тэмдэг болсон шонхор шувууг байрлуулна.

2.Таних тэмдэгний хэмжээ: дотор тойргын диаметр 5 см, гадна тойргын диаметр 6 см байна.

3.Таних тэмдгийг энгэрт зүүж хэрэглэнэ.